



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/35

Өвт

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бат-Өлзий сумын газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг “Дижиталмэппинг” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.

2. “Дижиталмэппинг” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Газрын даамал (И.Маралмаа)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг гэрээний дагуу орон нутгийн төсвөөс зарцуулахыг Санхүүгийн албаны нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ